



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/399

Мандалговь

Эзэмшил газрын нэр өөрчлөх тухай

Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт Залуучууд хотхоны баруун Буяаннэмэхийн өргөн чөлөө-1-101 тоот, мөн 4 дүгээр цэцэрлэгийн баруун талд Буяаннэмэхийн өргөн чөлөө-1-100 тоот байршилтай "Онцгой байдлын хэлтэс"-ийн нэр нь өөрчлөгдөж "Онцгой байдлын газар" нэртэй болсон тул газрын гэрчилгээг шинэчлэн эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх байгууллагатай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг ГХБХБГазар, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулж аймгийн Засаг даргын 2012 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/560 тоот захирамж, 2008 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 220 тоот захирамжийн Онцгой байдлын хэлтэст холбогдох хэсэг, мөн газар эзэмших 0381982, 0180304 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010282